




Байгаль, зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг (WCS)-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газар



*Онгон зэрлэг байгаль , амьтан
түүний амьдрах орчныг судалж
илрүүлэх... хамгаалах... сурталчилах*

Танилцуулга

Зэрлэг амьтдын судалгаа

Зайлшгүй хамгаалах 8 зүйл амьтан

Тууртан амьтад

Шүлхий

Шувууны томуу

Орон нутгийн хамтын ажиллагаа

Малчны нөхөрлөл

Тусгай хамгаалалтай газар

Зэрлэг амьтдын хулгайн ан, хууль бус худалдаа

Хөгжил ба байгаль хамгаалал

Дэд бүтэц

Үүл уурхай



Бидний эрхэм зорилго

Байгаль, зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг (WCS) нь Олон улсын хэмжээнд зэрлэг ан амьтан болон түүний амьдрах орчныг хамгаалахад гол үйл ажиллагаагаа чиглүүлдэг. Үүнийгээ нутгийг иргэдийн оролцоотойгоор судалгаа шинжилгээ, хамгаалалт, сургалт, сурталчилгааны ажлыг хамтад нь хамтран хэрэгжүүлдэг.



Нэмрөгийн дархан цаазат газар



Цэн тоторуу

Байгаль, зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг (WCS) –ийн Монгол дахь Төлөөлөгчийн газар нь Дорндоюн тал хээр, Өмнийн.govийн амьтан тэдгээрийн амьдрах орсныг судлах, хамгаалахад гол анхаарлаа хандуулан ажиллаж байна. Бид шинжлэх ухаан дээр суурилсан, урт хугацааны тогтвортой байгаль хамгааллын үйл ажиллагаа явуулахыг эрмэлзэж байна. Бид төрийн болон төрийн бус байгууллага, орон нутгийн ард иргэд, хувийн хэвшил, малчдын нөхөрлөлүүдтэй хамтран ажилласнаар биологийн төрөл зүйл, ялангуяа нүүдлийн амьтдын коридор газрыг хадгалан хамгаалах, байгалийн нөөцийг тогтвортойгоор ашиглахыг дэмжиж ажилладаг.

Манай байгууллагын түүхэн замнал

Хойд Америкийн том хөхтөн амьтны нэг болох Бизон буюу Бух гөрөөсийг тухайн үед их хэмжээгээр агнаасны улмаас тоо толгой нь эрс цөөрч устах аюулд хүрсэн тул энэ зүйл амьтныг хамгаалах зорилгоор анх 1895 онд одоогийн манай байгууллага байгуулагдсан түүхтэй. Одоогоор WCS нь дэлхийн 60 орчим оронд 500 гаруй төсөлт хөтөлбөр хэрэгжүүлж байна. WCS -ийн нэргт эрдэмтэн Жорж Шаллер анх 1989 онд Монгол улсад ирж цоохор ирвэс, хүрэн баавгай, хавтгай, аргаль, цагаан зээр судалж эхэлснээр Байгаль, зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг (WCS) –ийн Монгол дахь Төлөөлөгчийн газар нээгдэх суурь тавигдсан.



©ganbayar/hureelen

Жорж Шаллер нь 1993 оноос UNDP-GEF-ийн санхүүжилтаар Зүүн бүсэд хэрэгжсэн Дорнодын БТЗ-ийг хамгаалах урт хугацааны төслийг хэрэгжихэд чухал үүрэг гүйцэтгэсэн хүн билээ. Байгаль, зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг (WCS) –ийн Монгол дахь Төлөөлөгчийн газар нь 2003 онд Улаанбаатар хотод албан ёсоор байгуулагдаж эхний том хөтөлбар болох “Зүүн бүсийн зүйлд тулгуурласан байгаль хамгаалал”, түүний дараа 2009 оноос SCAPES буюу “Тэргүүлэх экосистемийг тогтвортой хамгаалах шийдэл” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн билээ. Сүүлийн 20- иод жилийн хугацаанд WCS нь зэрлэг амьтдын хулгайн агнуур, худалдаа, нүүдлийн амьтдын тархалт, шилжилт хөдөлгөөн, тархалт, өвчлөл, тоо толгойн судалгаануудыг хийсээр ирсэн. Мөн тусгай хамгаалалттай газар, малчдын нөхөрлөлүүдэд дэмжлэг үзүүлэх, байгаль орчны эрхзүйн орчин, түүний хэрэгжилтийг сайжруулахад дэмжлэг үзүүлж ажиллаж ирснээс гадна уул уурхайн болон бусад дэд бүтцийн төлөвлөлтийг нүүдлийн амьтдын нүүдэл, шилжилтэд ээлтэйгээр бүтээн байгуулах тол дээр анхааран ажиллаж байгаа болно.


WCS-ээс хэрэгжүүлдэг үндсэн үйл ажиллагааны нэг нь орчин үеийн шинжлэх ухааны аргазүй дээр суурилсан зэрлэг амьтдын тоо толгой, зан төрх, тархац, нүүдэл, шилжилт хөдөлгөөний горим, үхэл хорогдол, өвчлөлийг байдалд хийж буй судалгааны ажлууд билээ.

Зүүн бүсэд Зайлшгүй хамгаалах шаардлагатай найман зүйл амьтад

Бид зэрлэг амьтдыг Ландшафтын түвшинд нь судлан үзэж Зүүн бүсийн төлөөлөл болсон 8 зүйл амьтдыг тодорхойлсон. Эдгээр найман зүйл амьтад нь энэ газар нутгийн биологийн төрөл зүйлд учирч буй аюул бэрхшээлийг тодорхойлоход гол ач холбогдолтой бөгөөд цаашид эдгээр амьтдыг хамгаалж үлдэж чадвал бүс нутаг буюу амьдрах орчин нь хамгаалагдаж үлдэх учиртай. Одоогоор цагаан зээр, цэн тогоруу, монгол тарваганы судалгаа түлхүү хийгдэж байгаа бөгөөд цуглуулсан мэдээлэл нь байгаль хамгааллын цаашдын менежментийг улам сайжруулахад нь нэмэр болж байна.



Зүйл 1: Цагаан зээр



Зүйл 2: Цэн тогоруу




Зүйл 3: Саарал чоно



Зүйл 4: Монгол тарвага



Зүйл 5: Идлэг шонхор



Зүйл 6: Буган хандгай



Зүйл 7: Тул загас



Зүйл 8: Дорнодын мэлхий

Тууртан амьтад

Бид шугаман трансектийн арга, телеметрийн арга ашиглан тууртан амьтны (цагаан зээр, монгол бөхөн, хулан адтуу хар сүүлтий) тоо толгой, шилжилт хөдөлгөөний горим, үхэл хорогдлыг судалж байна. Одоо байгаа болон шинээр баригдаж буй төмөр зам, засмал замын төслүүдэд нүүдлийн амьтдын нүүдэл, шилжилт хөдөлгөөнд үзүүлж буй нөлөөг судлан тогтооход радио дамжуулагч хүзүүвч ашиглах арга нь маш ач холбогдолтой, давуу талтай юм.

Шүлхий

Шүлхий өвчний гарал үүсэл, түүний халдвар дамжих байдал нь ард иргэдийн дунд, нэн ялангуяа малчдын дунд маш маргаантай байдаг. Судалгаагаар цагаан зээр нь шүлхий өвчин тараадаг биш, харин өөрөө энэ өвчний хохирогч болдог нь тогтоогдсон байдаг. Судалгааны энэ дүгнэлт нь Монгол улсын Засгийн газраас энэ өвчний эсрэг авах арга хэмжээний талаар баримтлах бодлогод нэн чухал ач холбогдолтой юм. Энэ талаар зав ойлголт өгч олон тооны цагаан зээрийг тээгч хэмээн үзэж устгахаас сэргийлэх үүднээс үндэсний хэмжээний хэлэлцүүлэг зохион байгуулж энэхүү өвчний талаар үнэн зөв мэдээлэл бүхий зөвлөмж, судалгааны тайланг боловсруулсан болно.

Шувууны томуу


WCS нь шувууны томуу өвчний өндөр хоруу чанартай H5N1 дэд хэвшлийн илэрлийг амьд шувууд дээр судалж, улирлын, жилийн хэлбэлзэл, чанарын нөлөөг тодорхойлох үүднээс маш олон жилийн турш судалгаа хийсэн. Өөр бусад судалгаануудаар бага хоруу чанартай H3N8 вирусыг илрүүлсэн байдаг. Мөн үүнээс үүдлээд шувуу болон адуунд илэрдэг энэхүү хоёр вирусын хоорондын харьцаа, шинж чанарыг судалсан болно.



Нөхөрлөлд суурилсан байгаль хамгаалал

Байгаль, зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг (WCS) нь Зүүн бүс буюу Хэнтий, Дорнод аймгийн малчдын нөхөрлөлүүдийн гишүүд, идэвхтэн байгаль хамгаалагчдыг нь зэрлэг амьтны ажиглалт мониторинг хийх, бизнес болон нөхөрлалөйн Менежментийн төлөвлөгөө болосруулж байгуулах, байгаль орчны хууль эрх зүйн мэдлэгийг нь дээшлүүлэхэд гол дэмжлэг үзүүлэн ажиллладаг. Учир нь гэвэл нутгийн ард иргэд, тэнд буй зэрлэг амьтад мөнхөд хамт оршин тогтоно учиртай.

Үүсэн байгуулагсан малчдын нөхөрлөлүүд нь өөрсдийн амьдарч буй нутаг орныхоо зэрлэг амьтан болох монгол тарвага, усны болон нүүдлийн шувууд, цагаан зээр болон бусад амьтдыг хамгаалах, ажиглалт мониторинг хийх, зүй зохистой ашиглах үүрэгт гол анхаарлаа хандуулж сүм орон нутгийн удирдлагуудтай харилцан ойлголцож хамтран ажиллах учиртай тул нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөө их чухал үүрэгтэй юм. Нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөөний гол зорилго нь тухайн газрын зэрлэг ан амьтны тогтвортой нөөцийг нь хамгаалснаар цаашид тогтвортой зүй зохистой ашиглах нөхцлийг өөрсдөө бий болгох явдал юм. Энэ талаархи хууль эрх зүйн орчин нь харьцангуй сайн бүрдсэн гэж хэлж болох бөгөөд нөхөрлөдүүдийг дэмжих ажлын хүрээнд Байгаль, зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг (WCS) нь Дорнод Монголын Нутгийн иргэдийн Байгаль Хамгааллын Холбоо (ДМНИБХХ) болон сүм орон нутгийн удирдлагуудтай нягт хамттан ажиллаж байна.



Малчны нөхөрлөлүүдтэй хамтарч ажилласан нь



Дорнодын Бахархалын аян (RARE campaign)

RARE Conservation хэмээн олон улсын байгууллага дэлхийн 50 гаруй улсад тухайн орны амьтны төрөл зүйл, орчных нь талаарх үнэн бодит ойголтыг өсгөснөөр ард иргэдэд нь нутаг орныхоо байгалийг хамгаалахад нь илүү урам зориг өгдөг Бахархалын аян хэмээх кампанит ажил зохион байгуулдаг.



Бахархлын аяны уриа

WCS Зүүн бүсийн хэмжээнд цагаан зээрийг хамгаалах бахархлын аяныг Тосон Хулстай Байгалийн Нөөц Газар болон Дорнод аймгийн төв болох Чойбалсан хотод зохион байгуулсан. Энэхүү кампанит ажлын гол зорилго нь ард иргэдэд цагаан зээрийн талаархи үнэн мэдээллийг тодорхой арга зүйн дагуу хүргэж энэ амьтны мэдээлэлтэй болгож, үнэлэх үнэлэмжийг нь дээшлүүлж улмаар цагаан зээрээрээ бахархах, хамгаалах эрмэлзлэлийг нь төрүүлдэг юм.



Чойбалсан хотод “Зориг сан”-гийн
Байгаль орчны манлайлагч нар



Дорнодын УТХГ-үүдийн Хамгаалалтын
захиргааны байр

Тусгай хамгаалалтай газрын менежмент

Байгаль, зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг (WCS) нь Дагуурын хээр, Өмнийн.govийн экосистемийг тогтвортой хамгаалахаад гол анхаарлаа хандуулан ажиллаж байна. Тухайлбал тус бус нутагт буй хил дамнасан Улсын тусгай хамгаалалттай газрууд болох Монгол Дагуур, Нөмрөгийн ДЦГ-уудын менежментэд дэмжлэг үзүүлэх ажил юм. Дагуурын хээр нь БНХАУ, ОХУ болон Монгол улсуудын газар нутгийг дамнан оршдог.

Иймд эдгээр хил дамнасан газар нутгийн нүүдлийг зэрлэг амьтад, усны шувуудыг зэрлэг амьтдыг хамтран хамгаалах ажил маш чухал тул манай байгууллагаас хил дамнасан ТХГ-уудын хамтын ажиллагааг нь дэмжих, Монгол Дагуурын ДЦГ-ын Менежментийн төлөвлөгөөг нь боловсруулж өгөх, байгаль орчны хуулийн хэрэгжилтийг сайжруулах, хулгайн ан, хууль бус худалдааг бууруулах, улмаар таслан зогсоох Хамтарсан баг байгуулж аймгийн хэмжээнд ажиллаж төрийн хууль сахиулах бүх байгууллагуудтай нягт хатман ажиллаж байна.



Нөмрөгийн отрядын Хилчид сургалтанд хамрагдav.



Зэрлэг амьтдын хууль бус худалдаа


Зэрлэг амьтдын хууль бус худалдаа нь дэлхийн хэмжээнд дээгүүр байранд ордог бөгөөд олон улс орныг хамардаг. Монгол улс ч мөн адил. Байгаль, зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг (WCS) нь зэрлэг амьтдын худалдааны талаархи судалгааг Монгол улсын хэмжээнд анх удаа зохион байгуулж “Зэлүүд тал: Монголын ан амьтны хууль бус худалдааны хямралтай асуудлууд” 2006, нэртэй том тайлан боловсруулан хэвүүлж олны хүртээл болгосон билээ. Энэхүү тайланг бичихэд маш олон айл өрх, захуудаас авсан мэдээ, судалгаа, гааль болон бусад газруудаас авсан албан ёсны тоо баримтуудыг ашигласан болно. Дүгнэлтээс хараход өдийн засгийн өндөр ашиг авчирдаг зэрлэг амьтдын худалдаа маш өндөр хэмжээнд явагдаж байдаг нь тодорхой байна. Тухайлбал, монгол тарвага, саарал чоно, шар үнэг, хярс үнэг, бараан хэрэм, цоохор ирвэс, хүрэн баавгай, шилүүс мий, мануул мий зэрэг амьтдын арьс үс маш их үнэд хүрдэг тул эдгээр амьтдыг ихээр худалдаалладаг нь илэрсэн.



Хууль бусаар худалдаалагдаж буй хөлдүү загас



Хууль бусаар худалдаалагдаж буй хөлдүү чоно



“Зэлүүд тал: Монголын ан амьтны хууль бус худалдааны хямралтай асуудлууд” 2006

Хууль бус антай тэмцэх үйл ажиллагаа

Дээрх тайландаа зэрлэг амьтдын хууль бус худалдааг таслан зогсоох талаар олон зөвлөмжүүд багтаж орсны нэг нь Байгууллага хооронлын хамтын ажиллагааг сайжруулах замаар хуулийн хэрэгжилтийг сайжруулах явдал гэж заасан байдаг: Үүнийг хэрэгжүүлэх үүднээс Зүүн бүсэд буюу Дорнод аймгийн Чойбалсан хотод зэрлэг амьтдын хууль бус худалдаа, хулгайн анг таслан зогсоох Хамтарсан баг байгуулж ажиллуулсан явдал юм. Энэхүү Хамтарсан багт аймгийн хэмжээнд төрийн хууль сахиулах үйл ажиллагаа явуулдаг Байгаль орчны газар, Цагдаагийн газар, Гаалийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Дорнодын УТХГ-ыуудын Хамгаалалтын захиргаа, Тагнуулын газар болон Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газар буюу Чойбалсан хотын захирагчийн алба, Дорнод худалдаа ХХК-д нэгдэн орж хамтран үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд Мэдээлэл хүлээн авах Шуурхай утас ажиллуулдаг юм.



Шалгалтын явцад хураагдсан цагаан зээр



Оюу Толгойн хамгаалагч наарт амьтны
бүтээгдэхүүн танин ялгах сургалт явуулав



Дэд бүтэц

Монгол улсын эдийн засгийн хөгжилд бүтээн байгуулалтын ажил нэн чухал үүрэгтэй байдгийг бид үгүйсгэхгүй. Гэхдээ бодлогогүй хөгжил Монгол улсын газар нутаг, зэрлэг амьтдад хохирол үүсгэх магадлал маш өндөр. Үүнээс урьдчилан сэргийлэх маш олон гарц, боломжууд бий. Өнөөгийн хурдацтай явагдаж буй хөгжил, дэд бүтцийн төлөвлөлтүүд нь нүүдлийн зэрлэг амьтдын шилжилт хөдөлгөөнд хохирол учруулах эрсдэл ажиглагдах болсон. Иймд бид Засгийн газартай хамтран нүүдлийн зэрлэг амьтдын гарц байгуулах улмаар эрх зүйн баримтуудад тусгах талаар хамтран ажиллаж байна.

Үүл уурхай

Бид мөн уул уурхайн салбартай хамтран ажиллаж байгаль, амьтан, ургамалд учруулж ямар нөлөө үзүүлж буйг хянах, мөн нөлөөллийг багасгах, дүйцүүлэн хамгаалах арга боловсруулах ажил дээр ажиллаж байна. Энэ ажлын эцсийн зорилго нь тухайн уул уурхайн нь үйл ажиллагааныхаа явцад тухайн нутаг дахь биологийн төрөл зүйлд илүү эерэг нөлөө үзүүлэх явдал юм.



©ganbayar/hureelen

Холбоо барих

Байгаль хамгааллын манлайлал хөтөлбөр (CLP)


WCS олон улсын хэмжээнд Байгаль хамгааллын манлайлал хөтөлбөр буюу Conservation Leadership Program ажиллуулдаг. Энэхүү хөтөлбөрийн шугамаар шалгарсан оюутныг судалгаа шинжилгээнд сууринсан байгаль хамгааллын төслийг санхүүгийн болон үйл ажиллагааных нь чиглэлээр дэмжиж хэрэгжүүлдэг хөтөлбөр.

Био шар айраг (Biobeer)

Олон жил үргэлжилсээр ирсэн Био шар айраг хөтөлбөр сар бүрийн хоёрдох пүрэв гарагт Байгаль, зэрлэг амьтдын хамгаалах нийгэмлэг (WCS) –ийн Монгол дахв Төлөөлөгчийн газар болон Лондонгийн Зоологийн Нийгэмлэг (ZSL) хамтран зохион байгуулдаг билээ. Энэхүү арга хэмжээгээр Монгол улсын Байгаль орчны салбарт гарч буй бодлого эрх зүй, хийгдэж буй судалгаа шинжилгээний ажил, хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн талаархи илтгэл сонсож хариулаан мэдээлэл солилцдог арга хэмжээ юм.

Facebook: www.facebook.com/wcsmongolia
Twitter: @WCSMongolia
Website: mongolia.wcs.org

www.facebook.com/biobeermongolia



Монгол Улсын Ерөнхийлөгч Ц. Элбэгдорж АНУ-д айлчлал хийх үеэрээ New York хотод WCS-ийн төвд уригдан ирэв. 2009 он



Байгууллагын хамт олон “Гарц” киноны нээлтэн дээр

Дэмжигч санхүүжкуулагч байгууллагууд:

Дэлхийн Банк
АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг
(USAID)
HEMO төсөл
Minnesota Center of Excellence for Influenza
Research and Surveillance (MCEIRS)

Global Environmentla Facility (GEF)
НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр
RARE Conservation
Trust for Mutual Understanding
Оюу Толгой ХХК

Түншүүд:

Байгаль орчин ногоон хөгжлийн яам
Зам тээврийн яам
Хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам
Ерөнхийлөгчийн тамгын газар
Монголын шинжлэх ухааны академийн
Биологийн хүрээлэн
Монгол улсын их сургууль
Зүүн бүсийн тусгай хамгаалалтай
захиргааны газар
Зүүн бүсийн нөхөрлөлийн холбоо
Монгол дахь Дэлхийн байгаль хамгаалах
сан (WWF)

The Nature Conservancy
Лондонгийн Зоологийн хүрээлэн
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
Дорнод аймгийн мэргэжлийн хяналтын
газар, Цагдаагийн газар, Хил хамгаалах
агентлаг
Монгол улсын мал эмнэлгийн ариун цэврийн
лаборатори
Гласговын их сургууль
Зэрлэг амьтан хамгаалах, судлах төв
Хүн төвтэй байгаль хамгаалал
Нутаг түншлэл ХХК



Манай албан газрын хаяг:

Сан бизнес центр 201 тоот
Амарын гудамж 29, Сүхбаатар дүүрэг
8-р хороо, Улаанбаатар, Монгол улс
Утас: 11323719